



## Токио-2020NE Олимпын аялал 3

2020 оны зуны олимп буюу албан ёсоор Олимпын XXXII наадам нь 2020 оны 7 сарын 24-ны өдрөөс 8 сарын 9-ний хооронд Японы Токио хотноо зохиогдох байсан юм. Токио хот 2013 оны 9 сарын 7-нд Аргентиний Буэнос-Айрес хотод болсон ОУОХ-ны 125-р чуулганаар тус наадмыг зохион байгуулах эрхийг авсан. Токио хот 1964 оны зуны олимпыг зохион байгуулж байсан бөгөөд 56 жилийн дараа дахин зохион байгуулах гэж төлөвлөсөн байв. **Гэвч дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас Токиогийн Олимпын наадам 1 жилээр хойшилж 2021 оны 07 сарын 23-аас 08 сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажилаа хангаж байна.**

### Ерөнхий мэдээлэл

**Улс:** Япон

**Чиглэл:** Токио

**Хугацаа:** 7 шөнө, 6 өдөр

**Эхлэх өдөр:** 2021-07-28 - 2021-08-03

**Код:** TOK210728-01

### Үзэх зүйлс

- Фүжи уул
- Кавагучи нуур
- Токио хотын аялал
- Спорт 3 тоглолт

### Үнэ

Сонголт 1 - Үндсэн: **6,690,000₮**

Тийзний үнэ: {number\_format(\$schedule->ticket\_price)} ₮

## Аяллын хөтөлбөр

### Өдөр 1. УБ-ТОКИО-ФҮЖИ

Энэ өглөө тогтсон цагт ОУ-ын нисэх буудалд цуглаад бүртгэлээ хийлгээд Токио хот руу ниснэ. 4 цагийн дараа Нарита Олон улсын нисэх буудалд газардаад хөтөч орчуулагчийн хамт унаагаар Фүжи уулын бүс нутаг руу явна. Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

### Өдөр 2. Фүжи уул

Өглөөний цайгаа зочид буудалдаа уусны дараа аяллаа эхэлнэ. Аяллын эхэнд дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн **Кавагүчи** нуурын байгалийн цогцолборт газарт очиж уулын дүүжин тэргэнд суух ба 2014 онд Юнескогийн Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн **Фүжи уул** – ыг харна. Фүжи уул нь Японы 108 галт уулын хамгийн өндөр нь бөгөөд далайн түвшнээс дээш 3776 метрт өргөгдсөн байна. 1706 онд хамгийн сүүлийн удаа дэлбэрсэн. Одоо 24 цаг галт уулын идэвхжилтийн хяналтад байдаг. Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

### Өдөр 3. Олимпын тоглолт

Өглөө эрт зочид буудалдаа өглөөний цайгаа уусны дараа Токио хот руу явна. Олимпийн наадмын дараах спортын тоглолтуудаас 2-ыг сонгож үзнэ.

**11:00 Жүдо 8 хүн**

**14:20 Волейбол 26 хүн**

**17:00 Жүдо 2 хүн**

**19:00 Хөнгөн атлетик 29 хүн**

**20:00 Ширээний теннис 2 хүн**

Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

### Өдөр 4. Олимпын тоглолт

3

Зочид буудалдаа өглөөний цайгаа уусны дараа олимпийн наадмын дараах спорт тоглолтуудаас 1-ыг сонгож үзнэ.

**11:00 Бокс 2 хүн**

**17:00 Жүдо 5 хүн**

**21:00 Хөл бөмбөг 28 хүн**

Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

### Өдөр 5. ТОКИО

Зочид буудалдаа өглөөний цайгаа уусны дараа Токио хотын аялал хийнэ. Эхлээд дэлхийн хоёр дахь өндөр цамхаг **Скай три** дээр гарч Токио хотыг тольдоно. Дараа нь Шибүяа дүүрэгт байдаг эзэндээ үнэнч **Хачико** нохойны хөшөө болон дэлхийд алдартай хамгийн олон хүн зөрдөг замын уулзвар гарцыг харна. Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

### Өдөр 6. ТОКИО

Энэ өдөр чөлөөт өдөр, өөрийн хүсэлтээр цагийг өнгөрүүлэх боломжтой.

### Өдөр 7. ТОКИО-УБ

Өглөөний цайгаа зочид буудалдаа уусны дараа Нарита олон улсын нисэх буудал руу явж ... нислэгээр Улаанбаатар хот руу ниссэнээр энэ удаагийн дурсамж дүүрэн аялал өндөрлөх болно.

## Аялалын зардалд багтсан

- 3-4 одтой зочид буудлын 1 өрөөнд 2-оор байрлах зардал  
хуудас 2 / 3

- Зочид буудлын өглөөний цай
- Токио хотод угтах үдэх унаа
- Фүжи уулын аялал
- Хөтөч-Орчуулагч
- Даатгал
- Тоглолтын тасалбар
- Визний хураамж

## **Аялалын зардалд багтаагүй**

- Олон улсын нислэгийн тийз
- Өдөр, оройн хоол
- Стадион руу ирж очих унааны зардал
- Хувь хүний хэрэглээний зардал